

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2023.12.27

Байгууллагын нэр:

Цагдаагийн ерөнхий газар

Нэгжийн нэр:

Алба, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн
байгууллага.

Албан тушаалын нэр:

Хамгаалалтын цагдаа

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТТ-9

Ажлын цаг:

8 цаг

Албан байрны албан ёсны байршил:

Алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан
цагдаагийн байгууллага.

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Байгалийн гамшиг, гал түймэр, хүн, малын гоц халдварт өвчин гарсан, гэнэтийн болон бусад аюул тохиолдсон, нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, террорист халдлага, онц болон дайны байдал зарласан, онц ноцтой гэмт хэрэг үйлдэгдсэн зэрэг зайлшгүй тохиолдолд өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ:

Албан тушаалын зорилго:

Цагдаагийн албаны тухай хуульд заасан гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх, шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдааны оролцогчдын аюулгүй байдлыг хангах, хуяглан хүргэх, албадан ирүүлэх ажиллагааг хэрэгжүүлэх, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх.

Албан тушаалын зорилт:

- Шүүх хуралдааны дэг сахиулах, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчдын аюулгүй байдлыг хангах.
- Яллагдагч, шүүгдэгчийг хуяглан хүргэх, шүүхийн дуудсанаар ирээгүй байгаа яллагдагч, гэрч, иргэний хэргийн хариуцагчийг албадан ирүүлэх ажиллагааг гүйцэтгэх.
- Удирдлагаас ирсэн үүрэг даалгаврыг цаг тухайд биелүүлэх.
- Хууль, тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн ажлын байрны зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах-Т, Харилцан гүйцэтгэх-Г, Хянах-Х, Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	<p>1.1. Шүүх хуралдааны танхимд үзлэг шалгалтыг хийх, шүүх хуралдааны оролцогчдод хуралдааны дэг сахих талаар зөвлөмж өгөх, гадна байрлуулах;</p> <p>1.2. Шүүх хуралдааны танхимын аюулгүй байдлыг хангаж, шүүгч, шүүх бүрэлдэхүүн шүүх хуралдааны танхимд орж ирэх, шүүх хуралдаан хаах хүртэлх хугацаанд шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчдын аюулгүй байдлыг хангаж ажиллах;</p> <p>1.3. Шаардлагатай гэж үзвэл шүүх хуралдаанд оролцогчид болон хурлын танхимд ирсэн бусад хүмүүсийн биедээ авч яваа зүйлийг шалгаж, галт болон хүйтэн зэвсэг, зэвсгийн чанартай бусад эд зүйл илэрсэн тохиолдолд тэмдэглэл хөтлөн түр хураан авч, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад хүлээлгэж өгөх;</p> <p>1.4. Яллагдагч, шүүгдэгч, ялтанд эмнэлгийн тусламж үзүүлэх шаардлагатай болсон тохиолдолд шүүх хуралдааны даргалагчийн зөвшөөрлөөр эмнэлгийн тусламж үзүүлэх;</p> <p>1.5. Цагдан хоригдсон яллагдагч, ялтны гар, хөл, хурууны гав болон бусад тусгай хэрэгслийг эргүүл, хамгаалалтын офицерын зөвшөөрлөөр тайлах;</p> <p>1.6. Саатуулах байранд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч нар цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан яллагдагч, ялтны холбогдох бичиг баримттай тулган шалгах, бие, эд зүйлд үзлэг хийж, хяналт тавьж, сонор сэрэмжээ дээшлүүлж ажиллах;</p> <p>1.7. Журмын 3.18. цагдаагийн алба хаагч нь шүүгч, шүүх хуралдаанд оролцогчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор биеийн хүч, нэг бүрийн тусгай хэрэгсэл, галт зэвсгийг хууль тогтоомжид заасны дагуу хэрэглэх.</p>	Хууль Тогтоомжийн хэрэгжилт, байгууллага, алба хаагчийн аюулгүй байдал хангагдсан байна.	Т Х Г Ш Г Г Ш
2 дугаар зорилтын хүрээнд	<p>2.1. Яллагдагч, шүүгдэгчийг хуяглан хүргэх ажиллагааны үед аюулгүй байдлыг хангаж, нууцлалыг чанд хадгалах;</p> <p>2.2. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2016 оны А/62 дугаар тушаал, "Тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрэл дохио тавьж хэрэглэх журам"-ыг хэрэгжүүлж ажиллах;</p>		Г Х

	<p>2.3. Яллагдагч, шүүгдэгч, хүлээлгэж өгөх, хүлээн авах алба хаагч, явах чиглэл, хугацаа, мэдээлэл дамжуулах, холбоо барих, тээврийн хэрэгслийн байршил тогтоох багаж, дуу, дүрс бичлэгийн болон холбооны хэрэгслийн бүрэн ажиллаж байгаа эсэхийг шалгах;</p> <p>2.4. Хүч нэмэгдүүлэн хуяглан хүргэх ажиллагаанд яллагдагч, шүүгдэгч саад учруулсан, эсэргүүцсэн, оргохыг завдсан, гаднаас халдан довтолсон тохиолдолд биеийн хүч, тусгай хэрэгсэл галт зэвсгийг хууль тогтоомжид заасан үндэслэл журмын дагуу хэрэглэнэ;</p> <p>2.5. Албадан ирүүлэх ажиллагааны үед хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хууль дээдлэх, цагдаагийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээг баримталж ажиллах;</p> <p>2.6. Журмын 16.3. тухайн иргэнд өөрийн албан тушаал, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, холбогдох хуулийн заалтыг танилцуулах;</p> <p>2.7. Албадан ирүүлэх ажиллагаанд биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсгийг хууль тогтоомжид заасан үндэслэл журмын дагуу хэрэглэх, соронзон бичлэг, дүрс, дуу бичлэг, гэрэл зураг, чанга яригч техник хэрэгсэл ашиглаж баримтжуулах;</p> <p>2.8. Албан үүрэг гүйцэтгэх үедээ олж мэдсэн хувийн болон хууль тогтоомжид заасан нууцыг задруулах, ашиглахыг хориглоно.</p>	<p>Байгууллагын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгч, эрсдэл тооцогдсон байна.</p>	<p>Х</p> <p>Г</p> <p>Т</p> <p>Г</p> <p>Г</p>
<p>3 дугаар зорилтын хүрээнд</p>	<p>3.1 Ажлын цаг ашиглалт, албаны бэлэн байдлыг хангаж ажиллах;</p> <p>3.2 Газар, хэлтсээс зохион явуулсан сургалт, соён гэгээрүүлэх ажилд бүрэн хамрагдаж ажиллах;</p> <p>3.3 Ажлын хариуцлага, сахилга ёс зүйг чанд сахиж ажиллах;</p> <p>3.4 Гадаад хэл, компьютерын мэдлэгээ сайжруулах;</p> <p>3.5 Бие дааж үйл ажиллагааны заавар журмыг судлах;</p> <p>3.6 Албаны бэлтгэл сургалтад тогтмол хамрагдаж бие бялдраа хөгжүүлэх.</p>	<p>Алба хаагчдын сахилга, ёс зүй дээшилж, эрх ашиг сонирхол хангагдсан байна.</p>	<p>Г</p> <p>Г</p> <p>Г</p> <p>Г</p> <p>Г</p>
<p>4 дүгээр зорилтын хүрээнд</p>	<p>Ажлын байрны зорилтын хүрээнд явуулах бусад үйл ажиллагаа:</p> <p>1. Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн ажлын байрны зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх;</p> <p>2. Шууд удирдах албан тушаалтнаас өгсөн хууль ёсны үүрэг даалгаварын биелэлтийг хангуулах;</p>	<p>Ажлын байрны зорилго, зорилт хангагдаж, цагдаагийн алба хаагчийн хуулиар хүлээсэн нийтлэг чиг үүрэг хангагдана.</p>	<p>Г</p> <p>Г</p>

	3. Албан хэрэг хөтлөлт, архивын журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;	Г
	4. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлж, байгууллагын ажилтнууд болон харилцагч, үйлчлүүлэгчид иргэдтэй зөв боловсон харьцах, ёс зүйн зөрчил, дутагдал гаргахгүй байх.	Г
	Шударга ёсны шалгуурыг хангах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар: 1. Авлига, хүнд суртлаас ангид байж хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн, шударга ёсыг эрхэмлэн "Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг чанд сахих; 2. Явцуу эрх ашиг сонирхолоос татгалзаж, цагдаагийн байгууллага, албаны нийтлэг эрх ашиг сонирхлыг эрхэмлэн ажиллах.	Г Г

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА:


Боловсрол	Бүрэн дунд ба түүнээс дээш боловсролтой.	
Мэргэжил		
Мэргэшил	Цагдаагийн мэргэжил олгох сургалтад хамрагдаж, төгссөн байх.	
Туршлага		
Ур чадвар	Дүн шилжилгээ хийх	-Албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах. -Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах
	Асуудал шийдвэрлэх	-Байгууллагын чиг үүргийн хэрэгжилтэд өөрийн ажил үүргийн оруулах хувь нэмэр, оролцоог ойлгодог. -Өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж чаддаг.
	Багаар ажиллах	-Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах -Багын хүрээнд өөрт ноогдсон үүргээ гүйцэтгэх.
	Бусад	


IV. АЛБАН ТУШААЛЫН ХАРИЛЦАХ СУБЪЕКТ:

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: Алба, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын газар, хэлтэс, тасаг, хэсгийн дарга	
Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо: Батлагдсан орон тоо.	Бусад харилцах субъект: Шууд харилцах байгууллага: Хариуцсан асуудлаар бусад яам, агентлагийн албан тушаалын адил болон түүнээс доош зэрэглэлтэй албан тушаалтан: Шууд бус харилцах байгууллага: Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хуулийн этгээд, иргэн: /Эдгээртэй харилцахдаа Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомж, үйл ажиллагааны журмын холбогдох заалтыг баримтална/

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ:

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
---	--

Албан тушаал: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭД ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА  Т.ГАНЗОРИГ 2023 оны 12 дугаар сарын 27 ны өдөр	Байгууллагын нэр:..... Шийдвэрийн огноо:..... Дугаар:.....
--	--

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:	
Байгууллагын нэр: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР	
Шийдвэрийн огноо: 2023 оны 12 дугаар сарын 27 өдөр.	
Дугаар: А/401	
ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА	 Т.СҮХБОЛД
2023 оны 12 дугаар сарын 27 ны өдөр	

ТАНИЛЦСАН:
Танилцсан албан тушаалтан.....
.....
20... оны дугаар сарын-ны өдөр